

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

• БШУ-ны Сайдын 2024 оны А/140 тушаалаар батлагдсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны хүүхдэд хоол, хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэхэд мөрдөх журам”-ын дагуу Үдийн хоолны үйлчилгээг үзүүлнэ.

• МУ-ын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 254 дугаар тогтоолын 1 дүгээр заалтын Ерөнхий боловсролын сургуулийн 1-5-р ангийн 1 хүүхдэд ногдох үдийн хоолны зардлыг 2500 /Хоёр мянга таван зуу/ төгрөгөөр тооцсоны дагуу хүүхдийн өсөлт хөгжлийг дэмжих, зайлшгүй шаардлагатай илчлэг, шим тэжээлийн шаардлагыг хангасан, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй хоол, хүнсний бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлнэ.

• 1 хүнд олгох бүтээгдэхүүний илчлэгийн хэмжээ, мөнгөн дүнг өөрчлөхгүйгээр санал болгож буй бүтээгдэхүүнийг сэлгэх замаар Үдийн хоолны цэсийг өөрчлөн олгож болно.

• Хүүхдийн хоол хүнсэнд орж байгаа бүтээгдэхүүнүүдийг Хүнс, Хөдөө аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2020 оны А/234, А/359 тушаалаар батлагдсан “Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн батлах жагсаалт”-ын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ангилал, тавигдах шаардлага, техникийн баримтыг баримтлан Үдийн хоол нийлүүлнэ.

Нэр төрлийн дугаар	Техникийн тодорхойлолт болон стандарт
Халуун хоол, шингэн уух юм / жимс жимсгэний шүүс, цай, хярам орно/	<ul style="list-style-type: none"> ➤ Түүхий эд материал нь гарал үүслийн бичиг, шинжилгээний бичигтэй байна. ➤ Экологийн цэвэр болон амин дэм эрдэс бодисоор баяжуулсан бүтээгдэхүүн байх ➤ Сурагчдын эрүүл мэнд, дур сонирхолд нийцсэн чанартай байх ➤ Амархан муудаж чанараа алддаг хүнсний бүтээгдэхүүн оруулахгүй байх ➤ Нэг сурагчийн үдийн хоолны өртөг 2500 төгрөгт багтсан байна. ➤ Хүнсний эрүүл ахуй аюулгүй байдлыг хангасан байх, технологийн карт ирүүлэх ➤ Өөрийн оронд үйлдвэрлэсэн болон байгалийн гаралтай жимс жимсгэнэ ба сүүн бүтээгдэхүүнээр хийгдсэн шингэн уух зүйл байна. ➤ Бүтээгдэхүүнд итгэмжлэгдсэн шинжилгээний байгууллагаар дүгнэлт гаргуулсан байх. ➤ Халуун хоолыг үр тариа болон гурвалжин, хөц будаа, амин дэмт хүнсний ногоогоор баяжуулсан байх

<p>Ерөнхий шаардлага</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Үдийн хоолны бүтээгдэхүүнийг эрүүл ахуйн шаардлага хангасан байранд чанарын баталгаатай хүнсний түүхий эд материалаар үйлдвэрлэх, мэргэжлийн ажилчидтай, зориулалтын тоног төхөөрөмж бүхий гал тогоотой байх ➤ Үдийн хоолны бүтээгдэхүүнийг гэрээт борлуулагчаар дамжуулах, хувь хүнээс худалдан авахыг хориглоно. ➤ Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангасан байх, технологийн карт ирүүлэх ➤ Бүтээгдэхүүнд итгэмжлэгдсэн шинжилгээний байгууллагаар дүгнэлт гаргуулсан байх ➤ Үдийн хоолонд орсон бүтээгдэхүүний нийц, зохицлыг зөв сонгосон байх ➤ Бараа бүтээгдэхүүн гарал үүслийн бичигтэй байх /гарал үүслийн бичиггүй бол МХГ-ын төв лабораторийн бичиг авах/ ➤ Ажилчдын эрүүл мэндийн шинжилгээний дэвтэртэй, шинжилгээнд бүрэн хамрагдсан байх ➤ Худалдаа үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх ➤ Үдийн хоолны цагаас 20 минутын өмнө амталгаа хийлгэж байх. ➤ Цагаа баримталж хоолыг түгээх ➤ Бүтээгдэхүүн хадгалах зориулалтын агуулахтай байх ➤ Тендерт оролцогч нь өөрсдөө үйлдвэрлэгч бол давуу тал болно.
--------------------------	---

Техникийн тодорхойлолт боловсруулсан:

Сургуулийн эмч

Нярав

Ш.Оюунцэцэг
Ц.Сувдмаа

Ш.Оюунцэцэг

Ц.Сувдмаа